

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.БАЗАРХАН
ТАНАА

2022.02.22 № 116
танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Dugnelt 2.18-TA

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Dugnelt 2.18-TA

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19168403.00</u>	<u>19241069.49</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	19168403.00	19241069.49
354	Хангамжийн материал	18296403.00	18369069.49
35420	Аж ахуйн материал	11162771.00	10721071.00
35440	Түлш, шатах тослох материал	1323968.00	975994.30
35460	Хүнсний материал	4352032.00	5214372.19
35470	Бусад хангамжийн материал	1457632.00	1457632.00
35600	Мал амьтад	872000.00	872000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>313051713.49</u>	<u>303195987.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	313051713.49	303195987.63
392	Биет хөрөнгө	263051713.49	253195987.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	261836864.31	261836864.31
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15293917.80	-24940876.53
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53680896.00	54279896.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50969517.48	-51490171.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18121518.00	18121518.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14856703.54	-15824816.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	3103890.00	3103890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3103890.00	-3103890.00
39217	Ном	10532574.00	11213574.00
393	Биет бус хөрөнгө	50000000.00	50000000.00
39301	Програм хангамж	206256.00	206256.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-206256.00	-206256.00
39303	Бусад биет бус хөрөнгө	50000000.00	50000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>332220116.49</u>	<u>322437057.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3211297.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3211297.00	0.00
413	Өглөг	3211297.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3211297.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>329008819.49</u>	<u>322437057.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	329008819.49	322437057.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108184325.00	108184325.00
51101	Өмч: - төрийн	108184325.00	108184325.00
512	Хуримтлагдсан үр дүн	198297065.98	191725303.61
51210	Өмнөх үеийн үр дүн	198297065.98	198297065.98
51220	Тайлант үеийн үр дүн		-6571762.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22527428.51	22527428.51

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>332220116.49</u>	<u>322437057.12</u>
---	--------------------------------------------------------	----------------------------	----------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	263996024.00	263,486,440.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3332376.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	3332376.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3332376.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3332376.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	260663648.00	263,486,440.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	249288200.00	251,967,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	249288200.00	251,967,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4,491,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,491,340.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9970200.00	7,028,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9970200.00	7,028,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1405248.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1405248.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	287291685.77	270,058,202.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287291685.77	270,058,202.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	277543069.77	262,237,652.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206104211.00	197,886,103.00
210101	Үндсэн цалин	188807971.00	182,397,571.00
210104	Урамшуулал	16889779.00	10,950,732.00
210105	Гэрээт ажлын хөлс	406461.00	4,537,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26005190.00	27,286,277.00
210201	Тэтгэврийн даатгал	17582741.82	19,237,977.00

210202	Тэтгэмжийн даатгал	2573431.66	2,012,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1385494.07	1,609,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421184.09	402,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4042338.36	4,024,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9778301.00	6,691,088.00
210301	Гэрэл, цахилгаан	1081819.00	956,000.00
210302	Түлш, халаалт	8696482.00	5,735,088.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4250479.00	3,115,406.70
210401	Бичиг хэрэг	354800.00	119,700.00
210402	Тээвэр, шатахуун	850000.00	1,369,885.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684900.00	778,900.00
210404	Ном, хэвлэл	189000.00	171,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2171779.00	675,921.00
2105	Нормативт зардал	8409261.00	10,995,888.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65300.00	99,000.00
210502	Хоол, хүнс	7109711.00	9,935,409.54
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1234250.00	961,479.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500,000.00
210604	Урсгал засвар	0.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	56000.00	136,800.00
210702	Дотоод албан томилолт	56000.00	136,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	549000.00	571,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	411500.00	171,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137500.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22390627.77	15,055,088.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,437,023.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7337100.00	1,482,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15053527.77	11,135,725.86
210904	Найдваргүй авлагын алдагдал		-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9748616.00	7,820,550.27

2132	Бусад урсгал шилжүүлэг	4511216.00	7,820,550.27
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1405248.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3105968.00	7,820,550.27
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5237400.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5237400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-23295661.77</u>	<u>(6,571,762.37)</u>
230001	Эргэж төлөгдөх зээл		-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-23295661.77</u>	<u>(6,571,762.37)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	198,297,065.98	329,008,819.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	198,297,065.98	329,008,819.49
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	198,297,065.98	329,008,819.49
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	198,297,065.98	329,008,819.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	198,297,065.98	329,008,819.49
D08	Тайлант үеийн үр дүн			-6,571,762.37	-6,571,762.37
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,184,325.00	22,527,428.51	191,725,303.61	322,437,057.12

Төгрөгөөр

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>260663648.00</u>	<u>263486440.00</u>
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	260663648.00	263486440.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	249288200.00	251967100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	249288200.00	251967100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4491340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4491340.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9970200.00	7028000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9970200.00	7028000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1405248.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1405248.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>260663648.00</u>	<u>262206440.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260663648.00	262206440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250701400.00	252488440.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199964500.00	201097400.00
210101	Үндсэн цалин	178536921.00	185608868.00
210104	Урамшуулал	16889779.00	10950732.00
210105	Гэрээт ажлын хөлс	4537800.00	4537800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25920900.00	27163300.00
210201	Тэтгэврийн даатгал	18656400.00	19115000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1815700.00	2012100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1453000.00	1609600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363100.00	402400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3632700.00	4024200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9754100.00	6528000.00
210301	Гэрэл, цахилгаан	956300.00	956000.00
210302	Түлш, халаалт	8797800.00	5572000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2911000.00	2562800.00
210401	Бичиг хэрэг	354100.00	119700.00
210402	Тээвэр, шатахуун	850000.00	945000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684900.00	778900.00
210404	Ном, хэвлэл	189000.00	171000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	833000.00	548200.00
2105	Нормативт зардал	4188800.00	9246800.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65300.00	99000.00
210502	Хоол, хүнс	3076500.00	8503800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1047000.00	644000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500000.00
210604	Урсгал засвар	0.00	500000.00
2107	Томилолт, зочны зардал	56000.00	136800.00
210702	Дотоод албан томилолт	56000.00	136800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450000.00	571000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	171000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7456100.00	4682340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3200000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7456100.00	1482340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9962248.00	9718000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4724848.00	9718000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1405248.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3319600.00	9718000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5237400.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5237400.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>0.00</u>	<u>1280000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	1280000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1280000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1280000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1280000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>0.00</u>	<u>-1280000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	258994900.00	258995100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258994900.00	258995100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249277100.00	249277100.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201097400.0 0	201097400.00
210101	Үндсэн цалин	185608868.0 0	185608868.00
210104	Урамшуулал	10950732.00	10950732.00
210105	Гэрээт ажлын хөлс	4537800.00	4537800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27163300.00	27163300.00
210201	Тэтгэврийн даатгал	19115000.00	19115000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2012100.00	2012100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1609600.00	1609600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	402400.00	402400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4024200.00	4024200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6528000.00	6528000.00
210301	Гэрэл, цахилгаан	956000.00	956000.00
210302	Түлш, халаалт	5572000.00	5572000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2562800.00	2562800.00
210401	Бичиг хэрэг	119700.00	119700.00
210402	Тээвэр, шатахуун	945000.00	945000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	778900.00	778900.00
210404	Ном, хэвлэл	171000.00	171000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	548200.00	548200.00
2105	Нормативт зардал	9246800.00	9246800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99000.00	99000.00
210502	Хоол, хүнс	8503800.00	8503800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	644000.00	644000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
2107	Томилолт, зочны зардал	136800.00	136800.00
210702	Дотоод албан томилолт	136800.00	136800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	571000.00	571000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	171000.00	171000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1471000.00	1471000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1471000.00	1471000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9717800.00	9718000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9717800.00	9718000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9717800.00	9718000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	258995100.0 0	258995100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251967100.0 0	251967100.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251967100.0 0	251967100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7028000.00	7028000.00
132001	Орон нутгийн төсвөөс	7028000.00	7028000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Төгрөгөөр		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4491340.00	4491340.00
УРСГАЛ ЗАРДАЛ	4491340.00	4491340.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4491340.00	4491340.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4491340.00	4491340.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4480000.00	4480000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11340.00	11340.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4491340.00	4491340.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	4491340.00	4491340.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4491340.00	4491340.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, сурагчдад стандартаар тогтоосон бага боловсрол олгох, эзэмшүүлэх, сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, багш нарыг чадавхжуулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх, хүүхдийг төлөвшүүлэх, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүд бэлтгэхэд оршино..

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас сургуулийн 2021 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 287.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 9.8 сая төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	19,168.4	19,241.0	72.6
Үндсэн хөрөнгө	313,051.7	303,195.9	-9,855.7
Нийт хөрөнгө	<u>332,220.1</u>	<u>322,437.0</u>	<u>-9,783.0</u>
Өр төлбөр	3,211.2	00	-3,211.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	329,008.8	322,437.0	-6,571.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>332,220.1</u>	<u>322,437.0</u>	<u>-9,783.0</u>

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19.2 сая төгрөг болж 0.07 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 31.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 31.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 1.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, үндсэн хөрөнгөд 11.1 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр 3.2 сая төгрөгөөр буурсан нь оны эхний өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 322.4 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 6.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 0.5 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь төсвийн санхүүжилтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 17.2 сая төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан цалин, хангамж бараа материал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 261.2 сая төгрөг, тодотгосон төсөв 259.2 сая төгрөг байна.

Тодотголоор анх баталсан төсвийг 2.0 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-ийн зардал 23.4 сая төгрөгөөр нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4.0 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 1.8 сая төгрөгөөр, хоол хүнсний зардал 19.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 259.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 259.0 сая төгрөгийг зарцуулжээ. Батлагдсан төсвөөс 0.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Нийт төсвийн 77.6 хувийг цалин, 10.6 хувийг НДШ-ийн зардал, 2.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.9 хувийг хангамж, бараа материалын зардал, 3.5 хувийг норматив зардал, 4.9 хувийг эд хогшил худалдан авах зардал, томилот, зочны зардал бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна..

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд 4,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой мэдээллүүдийг бүрэн толилуулан, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус 2 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай цалин, НДШ-ийн зардал тогтмол зардал, хоолны зардал, үдийн цайны зардал, нийтдээ 253.0 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.0 сая төгрөгийн зардлын тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.6 сая

төгрөг хэмнэх тооцоо гарч байгаа ба төсвөөс хэмнэлт гаргаагүй тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжилт хангагдаагүй байна гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 онд нийт 260.4 сая төгрөгийн 18 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 260.0 сая төгрөгийн 17 мэдээллийг хугацаандаа байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөр барагдуулах акт тогтоов.

1.Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолонд өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 2376 хүүхдэд 8,479.7 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг 0.2 сая төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс илүү хууль бус зарлага гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, 45 дугаар зүйлийн 45.2, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын норматив тогтоох тухай” журмын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь гүйцэтгэлээр 259.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 5.4 сая төгрөгийн төсвийн 10 хувь 0.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцоолж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

		Тоо	Дүн								
1	Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	2	0.7			1	0.2	1	0.5		